

НОМ ЗҮЙ, ЛАВЛАХ

**НЭГЭН ЭМХТГЭЛИЙН
ТАЛААР ТОВЧХОН**

«Монголын түүх судлал» 1985 он Хөх хот*

БНХАУ-д «Хятад улсын монгол түүхийн шинжилгээний нийгэмлэг»-ийг 1979 онд байгуулахдаа «Монгол түүх судлал» сэтгүүлийг гаргахаар төлөвлөсөн ажээ. Сэтгүүлийн анхны дугаарыг 1985 оны 7-р сард Хөх хотноо Өвөр Монголын багшийн их сургуулийн хэвлэх үйлдвэрт хэвлэн нийтэлжээ. Хэвлэлийн редакцид гурван монгол, хоёр хятад хүн орсон байна.

Уг эмхтгэлд монгол хэлээр Лю Жинскогийн бичсэн «Чингис хааны эзэнт улс байгуулагдахаас өмнөх Монголын нийгмийн байгууламж», Чойжийн «Ширээт гүүш Цоржийн тухай нэмж өгүүлэх зүйл» Эрдэнэ нарын «Түрүүн дөрвөн Ойрдын холбоо», хятад хэлээр профессор «Вэнь Дуця» -ний бичсэн «Эмхтгэлийн оршил», Чэнь Чи Инь нарын «Мөнх хааны үеийн Монгол, Төвдийн харилцаа», Ху Сижэнь нарын «1257 онд байгуулсан Шигимун сүмийн тухай нотлон тайлбарлах», Бай Цюйчингийн «Ойрдын нутаг шилжсэн тухай шинжин өгүүлэх нь», Буянхүү нарын «Улс байгуулагдсанаас хойших манай улсын Монголын түүх судлалын тойм байдал», япон хэлээр В. Хирошийн бичсэн «XVII зууны дунд үеийн халимагууд ба зүүн Туркестан», герман хэлээр өрнөд Германы Валтхер Хейссигийн бичсэн «Алтан хааны намтрын нэгэн эх сурвалж» гэх зэрэг хорь шахам өгүүлэл, материал, тойм, мэдээ нийтлэгджээ.

Энд нийтлэгдсэн эрдэм шинжилгээний чанартай материалуудаас уншиж үзэхэд БНХАУ-д монголын түүх судлалын ажлын зохион байгуулалт нарийсч, мэргэжлийн судлагчдын тоо олширч, судалгааны ажлын цар хүрээ өргөжин байгаа нь илт байна. Уг эмхтгэлд дурдсанаар Хятад улсад өнөөгийн байдлаар Монголын түүх судлалын холбогдолтой арав гаруй газар байгуулагдаж, тэдгээрт нэг зуу гаруй хүн байнга ажиллаж, улс төр, эдийн засаг, цэрэг, соёл, түүхэн газар зүй зэрэг төрөл бүрийн сэдвээр жилд зуу гаруй өгүүлэх материал нийтлүүлж байгаа ажээ.

Өгүүлэн буй эмхэтгэлд Өвөр Монголын их сургуулийн Монголын түүхийг судлах газрын ажилтан Буянхүү нарын бичсэн «Улс байгуулагдсанаас хойших манай улсын Монгол түүх судлалын тойм байдал» өгүүлэлд «Манай улс бол үндэстний өлгий нутаг, дэлхий дээр монгол угсаатны хамгийн олон хүн амтай орон мөн» гэж өгүүллээ эхэлсэн байна. Мөн цааш нь тэдний бичсэн зарим өгүүлэлд монголчуудыг хэзээ нээс нааш хятадын «их гэр бүлийн хэсэг гэдэг санааг агуулсан зүйл харагдаж байна.

Эмхэтгэлд орсон материалуудыг нэгдүгээрт, Монголын түүхийн зарим түүхт үйл явдалд нэлээд бодитой юмуу гэмээр дүн шинжилгээ хийсэн; хоёрдугаарт, зарим өгүүлэл, тайлбаруудыг бичсэн зохиогчид түүхэн үйл явдлыг болсон бодит байдлаар нь бичихийн оронд хятадын үндсэрхэг үзэлтэй маоист түүхчдийн онолын үүднээс тайлбарлаж, хятад улс

* «Мэнгу лиши яньцзю» 1985 он. Хөх хот

бол хамгийн олон монгол хүн амтай бөгөөд монголчуудын үүсч хөгжсөн өлгий нутаг нь хятадад байна. Мөн Монголын түүхийн холбогдолтой үнэт сурвалж материалыг хадгалж цуглуулсны хувьд дэлхий дээр хятад улс тэргүүн байранд орох учир монгол үндэстний холбогдолтой бүх төрлийн судалгааны төв нь Хятадад байх ёстой гэх мэт үзэл санааг нотлохыг оролдсон ийм хоёр чиглэлд хувааж болох юм.

Ө. Батсайхан